

## Дизайн технологийн хичээлийн дадлага ажлын материаллаг хэрэгцээг шийдэж , хичээлийн үр дүнг сайжруулах боломж



Унзад овогт Ламжавын Даваадорж Орхон аймгийн ЕБ – ын 13 –р сургуулийн Дизайн - технологийн багш, Боловсролын тэргүүний ажилтан, МУ - ын Зөвлөх багш. Хөдөлмөрийн хүндэт медальт. Боловсрол судлалын магистр. 2010 онд Улсын Техник технологийн III давааны олимпиадаас Хүрэл, 2012 оны Улсын Техник технологийн III давааны олимпиадаас Алтан медаль хүртсэн. Орхон аймгийн Боловсрол, соёлын газрын 1999, 2001, 2002 оны “ Тэргүүний арга зүйч “ - ээр, 2009, 2010 оны Аймгийн “ Мэргэжлийн аварга багш “, 2011, 2012 оны Орхон цогцолбор сургуулийн Тэргүүний сургалттай “ Мэргэжлийн аварга багш”, 2012 онд Аймгийн Боловсрол, соёлын салбарын “ Оны тэргүүний ажилтан “ аар, 2014 онд Эрдэм ахлах сургуулийн “ Оны тэргүүний багш “, “ Мэргэжлийн аварга багш “ “, 2017 онд 13 – р сургуулийн “ Сургуулийн сайн арга зүй технологитой багш “ – аар тус тус шалгарсан. Мэргэжлийн 15 төрлийн ном, гарын авлага, 35 зөвлөмж, Сурган хүмүүжүүлэх эрдэм шинжилгээний илтгэл 29, 60 гаруй бүлэг нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан, хэвлүүлж мэргэжил нэгт багш нарынхаа хүртээл болгосон. Шавь нарын амжилтаас товч дурдвал: Улсын техник технологийн II, III олимпиадаас сүүлийн 10 жилд Алт 21, Мөнгө 35, Хүрэл 27 хүртсэн байна.

**Түлхүүр үг :** Тогтвортой хөгжлийн боловсрол , төсөлт ажил, арга туршлага

**Сэдэв сонгосон үндэслэл :**

Бүх шатны боловсролын агуулгыг тогтвортой хөгжлийн төлөөх үзэл баримтлалаар баяжуулан эх дэлхий, онгон байгалийнхаа баялаг өвийг хайрлан хамгаалах, экосистемийн тэтгэх даацаас нь хэтрүүлэхгүйгээр зохистой хэрэглэх, боловсрол, хүмүүжил, хандлагыг ирээдүй хойч үеийнхэндээ төлөвшүүлэх замаар амьдралын нөхцлийг сайжруулахад чиглэсэн боловсролыг эзэмшүүлэх шинэ зорилт бидний өмнө тулгарч байна.

Дизайн технологийн хичээл дээр сурагчдын бүтээлч үйл ажиллагааг төлөвшүүлэх, сэтгэн бодох чадвар, урлаж бүтээх эв дүй, сэтгэлгээг хөгжүүлэхэд материалын төрөл, ангилал, олдоц хүртээмжтэй байдал нь өнөөгийн зах зээлийн нийгэмд тулгамдсан асуудал хэвээр байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд багш бүр өөрийн арга барил, орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тулгуурлан ажиллаж байгаа билээ. Өнөөдөр дизайн технологийн дадлага хичээл материалын эрс хомсдолд явагдаж байна. Үүнээс гарах арга зам нь дахин ашиглах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалж ,зөв зохистой ашиглах, сургуулийн хэмжээнд аян зохион байгуулж, сургалтын материаллаг хэрэгцээг шийдэх бүрэн боломжтой гэж үзэж энэ сэдвийг сонгож авсан юм.

**Зорилго :**

Дадлага ажлын хичээлийн материаллаг хэрэгцээг шийдэж , дахин ашиглах боломжтой материалуудыг ( лааз, хуудсан металл, эвэр яс, хуванцар, мод, цаас, гэх мэт ... ) ашиглаж өөртөө болон бусдад хэрэгцээтэй эдлэл зохион бүтээж хийх , хичээлийн үр дүнг дээшлүүлэх

**Зорилт :**

- Дизайн технологийн 6 – 12 - р ангийн хичээлээр дахин ашиглах боломжтой материалуудыг хэрэглээнд оруулж , бүтээл хийх боломжийг судлах
  - Дадлага хичээлийн үр дүнг дээшлүүлэх арга замыг хайж олох, судалгаа дүгнэлт хийх
  - Гарсан үр дүн, санал шийдлээ мэргэжил нэгт багш нартаа түгээн дэлгэрүүлэх
- Судалгааны ажлын шинэлэг тал :**
- Дахин ашиглах боломжтой материалыг ашигласнаар, байгаль дахь хог хаягдал багасах, хийсэн бүтээлийнхээ үр шимийг хүртэх, амьдрах арга ухааны арга барил төлөвших
  - Суралцагчдад уламжлалт гар урлал , зан үйлтэй холбоотой урлалын төрлийг таниулах

**ОРШИЛ**

Уг сэдвээр урьд өмнө Оросын эрдэмтэд Маргарита Павлова, Ю.Л. Хотунцев, Шведийн эрдэмтэн профессор Лейф Остман, Монголын эрдэмтэн Э. Раднаа, доктор (Ph.D), профессор Д.Сэрээтэрдорж, Г. Чулуунаа, Д.Хөхөө, Л. Цэрэнсодном, Ч. Болортуяа нарын олон эрдэмтэд судлаачид хөдөлмөр сургалт, технологийн боловсролын үндэс суурийг тавих, технологийн боловсролын онолын үндэс, дидактикийг боловсруулан технологийн боловсролын чиг хандлагыг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулсныг дурдаж болно.

- “ ... дээд тэнгэртээ залбирч, дэргэдэх хайрхандаа мөргөж” гэгчээр байгаль орчноо хамгаалж ирсэн соёлын өв уламжлалыг Бага, дунд боловсролын агуулгад тусгах санааг Д. Сэрээтэрдорж, Г. Чулуунаа, Ч. Болортуяа “ Тогтвортой хөгжилд хүргэх, боловсролын асуудал “ өгүүлэлдээ дэвшүүлсэн байна.
- Ийм учраас байгаль орчноо хамгаалахад хүүхдүүдийн оролцооны ямар хэлбэрүүд байж болохыг ( жишээ нь : Амьдарч байгаа орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх, цэцэг, мод, бут сөөг, хүнсний ногоо тариалах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөв зохистой ашиглаж, бүтээл хийх аргад суралцуулах, түлшнээс бусад зүйлийг гэрийн нөхцөлд шатаахгүй байх, булаг шандын эхийг сэргээх, хамгаалах, усыг гамтай зарцуулах, ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх зэргийг сургалтын агуулгад тусгах өгөх нь зүйтэй санагдаж байна .
- Доктор Маргарита Павлова “ Тогтвортой хөгжлийн загварын хүрээнд Технологийн боловсролыг концептуалчлах үндэс “ өгүүлэлдээ Тогтвортой байдлын нийгмийн болон соёлын талууд болох Уламжлалт гар урлалын төрлийг Технологийн боловсролын агуулгад тусгахыг зөвлөсөн байна.
- Миний судалгааны ажлын онцлог, хичээлийн арга зүйн үндэс нь ХҮҮХДИЙН СУУРЬ ШИНЖИД нь тулгуурлан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зөв зохистой ашиглаж, бүтээл хийлгэж сургах, суралцагчдын СЭТГЭН БОДОХ, САНАА БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, УРЛАН БҮТЭЭХ гурван чадварыг хослуулан, жигд хөгжүүлэхэд оршино.

#### **СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ**

- Дахин ашиглах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалж, бүтээл хийж ашигласнаар, байгаль дахь хог хаягдал багасах, хийсэн бүтээлийнхээ үр шимийг хүртэх, өөрөө өөрийгөө, баг хамт олныхоо хийсэн бүтээлийг үнэлж дүгнэж сурах, түүгээрээ бахархах, амьдрах арга ухаанд суралцах

#### **СУДАЛГААНЫ АРГА :**

Тухайн сэдвийг судлахдаа сургалтын танин мэдэхүйн үндэс болох судалгаа шинжилгээний агуудаас баримт материал цуглуулах, бүтээлээр үзүүлэх, сурагчдаар бүтээл хийлгэж турших, ажиглалт хийх, харьцуулах зэрэг аргуудыг хэрэглэж, тухайн сэдэвтэй холбоотой ном зохиол, сэтгүүл, бүтээлийг судлах, нэгтгэн дүгнэх ажлыг гол аргаа болгов.

#### **ҮНДСЭН ХЭСЭГ :**

Дизайн технологийн хичээлийн явцаас харахад дадлага ажлын хичээлээр эдлэл, зохион бүтээж хийхэд материалын хүрэлцээ, хангамж дутмаг байгаа учраас онолын хичээл илүү давамгайлах байр суурь харагдаж байна. Сурагчдад мэдлэг олгодог ч мэдлэг бүтээх үйл явц дутмагаас хичээлийн үр дүн хангалт муутай гарах дутагдал байна. Иймд өөрийн санаагаа дэвшүүлэн тавьж батлах оролдлого хийв. Үүнээс гарах нэг гарц нь тогтвортой хөгжлийн боловсролын агуулгын хүрээнд сурагчдын сонирхол, хэрэгцээнд нь тулгуурлан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал материал зөв зохистой ашиглан өөртөө болон бусдад хэрэгцээтэй зүйл сэдэж зохиох, урлан бүтээх ажлыг хийлгэж, байгаа нь дадлага ажлын хичээлийн үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн үед Дизайн технологийн бага, дунд боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн боловсролыг тусгах талаар эрдэмтэн, судлаачид хэд хэдэн шинэлэг санааг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд :

- Технологийн хичээлийг тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлэх гол хичээл гэж Шведийн профессор Лейф Остман үзэж байна.

- Г. Чулуунаа “ Технологийн хичээлд төслийн арга хэрэглэх нь “ номондоо Тогтвортой хөгжлийн боловсролын арга зүй нь “ Төсөл “ – ийн ажил байна гэж үзсэн байна.
- Д.Сэрээтэрдорж доктор (Ph.D), Урлахуйн ухааны сургаалийн үндэс бие, хэл, сэтгэлийн нууц “ Нууц хураангуйн онол “ судрын тайлал “ өгүүлэлдээ ... Бие, хэлийг бясалгаж, гараар урлахуйг сэтгэн үйлдвэл, Биеийн ур, хэлний ур, сэтгэлийн ур нийлж , урлал үйл сая төгс бүтээгдэнэ гэж өгүүлэлдээ тайлбарласан байна. “ Нээлттэй хичээл “ сэтгүүлийн 2009 оны № 07. хуудас 12 - 13 )
- МУ – ын Зөвлөх багш Л. Даваадорж миний бие Улсын Техник технологийн III давааны эрдэм шинэжилгээний “ Монгол урлахуй ухааны уламжлалт технологид суурилж технологийн боловсролыг хөгжүүлэх нь “ илтгэлдээ Уламжлалт урлахуйн ухааны онолын ёсоор бол хүний суурь шинж нь бие, хэл сэтгэлийн тогтолцоо юм гэсэн санааг дэвшүүлэн тавьж сургалт хүмүүжлийн ажилдаа хэрэгжүүлж ирсэн билээ.


Дээрх тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаануудыг нэгтгэн дүгнэж хэлэхэд :

1. Хүүхдийн суурь шинжид нь тулгуурлан дахин ашиглах боломжтой материалуудыг нөөцлөн, зөв зохистой ашиглаж, төслийн аргаар бүтээл хийлгэж сургах
2. Бүтээл хийлгэж сургах явцдаа сурагчдын сэтгэн бодох , санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх , урлан бүтээх гурван чадварыг хослуулан , жигд хөгжүүлэх нь чухал юм.

Хаягдал материалыг дахин ашиглах нь тогтвортой хөгжлийн нэг хүчин зүйл байгаль экологид халгүй технологи юм. Хог хаягдлыг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, хортой хог хаягдал гэж хоёр ангилдаг. 2004 онд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль батлагдсан. Тогтвортой хөгжлийн боловсрол болон дизайн технологийн боловсролын уялдаа холбоог дараахь байдлаар тодорхойлж байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын зорилго	Дизайн технологийн боловсролын зорилго
Суралцагчдад байгаль ахуйн хувьд сүйрэлгүй , эдийн засгийн хувьд үр ашигтай , нийгмийн хувьд шударга байх орчинг ардчиллын үнэт зүйл үндсэн зарчим, соёлын олон талт байдлыг тооцон бүрдүүлэхэд идэвхтэй оролцуулах чадварыг эзэмшүүлэхэд оршино.	Мэдээлэл технологийн эрин үед технологийг сонгон хэрэглэж, зохион бүтээж чаддаг ,технологийн нийгэмд болон байгаль орчинд үзүүлэх эерэг ба сөрөг үр дагаврыг ойлгож үнэлж чаддаг тийм иргэнийг төлөвшүүлэх явдал юм.

“Тогтвортой хөгжил” гэдэг нь “байгаль орчин, нийгэм, эдийн засаг гэсэн гурван асуудлыг нягт хамаарал шүтэлцээтэй авч үзэж байгалийн хишиг, нөөц, баялаг өгөөжийг зүй зохистой ашиглан, өнөө болон хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийн төлөө нийгмийг бүтээн байгуулах” гэсэн утгыг илэрхийлдэг.



- Байгалиа унаган төрхөөр нь хадгалж хойч үедээ өмчлүүлж ирсэн уламжлал алдагдахад хүрч байна.
- Өөдөс хаягдал бидний нэрлэж заншсанаар “Хоёрдогч түүхий эд” нөөцлөж, дахин ашиглах замаар хүрээлэн буй орчноо хог хаягдалгүй байлгах уламжлал нь улс орнуудад төстэй байсан байна.
- Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан хүрээлэн буй орчноо /байгаль/ хамгаалж, хойч үедээ өвлөн үлдээж болох юм гэсэнтэй санал нэгдэж, төр засгийн тэргүүнүүд үе үе уулзалт зохион байгуулах, НҮБ-аас зөвлөмж гаргах, улс орнууд Тогтвортой хөгжлийн боловсролоор үндэсний хөтөлбөртэй болж, сургалтын агуулга, сурах бичигт тусах болсон нь сайн талтай.


Тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд 6 – 12 ангийн 65 сурагчаас Байгаль орчноо хамгаалж ирсэн уламжлалаа хэрхэн мэдэх вэ? Асуулгаар судалгаа авахад 57 хувь нь дунд , 2 дахь асуултанд 46 % дунд зэрэг , хангалтгүй 9% нь хариулснаас харахад энэ талын мэдлэг тааруу байгаа нь харагдаж байна. Ийм учраас Байгаль орчноо хайрлан хамгаалах болон хог хаягдлыг дахин ашиглах, хийх арга технологийн мэдлэг, хүмүүжлийг хичээлээр дамжуулан олгох, 6 – 12 ангийн хөтөлбөрийн агуулгад тусгаж өгөх нь зүйтэй.



**Дизайн технологийн 6 – 12 ангийн хичээлээр хэрэглээнээс гарсан дахин ашиглаж боломжтой материалуудыг нөөцлөж бүтээл хийх боломжийг судалсан нь :**

Дизайн технологийн сурах бичгийн агуулгад Дахин ашиглах боломжтой материалуудыг хэрхэн ашиглах тухай , судалж үзэхэд *Дизайн технологи VII ангийн сурах бичгийн 114 – 124 хуудсанд* Малын эвэр яс боловсруулах, Хуучин хувцас болон савхины өөдсөөр зохион бүтээж хийх тусгай бүлэг сэдвийг, *Зураг зүй технологи II ангийн сурах бичгийн 178 – 188 хуудсанд* Төрөл бүрийн лааз, төмөр утас, хуудсан металлын өөдөс, техникийн эд ангиудаар бүтээл хийх, *Зураг зүй технологи III ангийн сурах бичгийн 156 – 162 хуудсанд* Хөөмөл хийх арга технологийн тухай, 164 – 176 хуудсанд Технологи ба тогтвортой хөгжил, Төслийн аргаар хичээл явуулах аргачлалыг 6 – 9 ангийн сурах бичгүүдэд оруулсан сайн талтай. Цаашид сурах бичгийн агуулгад тогтвортой хөгжлийн боловсролын тухай , дахин ашиглах боломжтой материалуудыг ( цаас, картон, үзэг балны гэр, хуванцар сав, ундааны лааз, модны өөдөс, даавууны өөдсүүд гэх мэт .. ) нөөцлөн хадгалж бүтээл хийх арга технологийг боловсруулж сурах бичигт тусгай бүлэг сэдэв оруулж өгөх нь зүйтэй санагдаж байна.

Дизайн технологийн хичээлээр дахин ашиглах боломжтой материалуудыг сургуулийн орчинд ангилан, ялгаж нөөцлөн хадгалж байгаа нь та бүхний сэтгэлд хэр нийцдэг вэ?



**Судалгааны дүгнэлт :** Судалгаанаас харахад бидний сэтгэлд сайн нийцдэг – 23 , нийцдэг - 27, дунд зэрэг 8 гэж хариулсан байгаа нь сайн талтай . Иймээс сургалтын орчинг бүрдүүлж, дадлага хичээлийг үр дүнтэй явуулахад дахин ашиглах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалж дахин боловсруулж ( төрөл бүрийн лааз, модны өөдөс, хуванцар, даавууны өөдөс, бөглөө, үзэг бал пламастрын гэр гэх мэт .... ) эд зүйл хийж, ашиглах нь чухал гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

**“ Дахин ашиглах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалж ,бүтээл хийх “ явцад ололтой болон анхаарвал зохих дараахь зүйл ажиглагдаж байлаа.**


3 багана	Ололттой зүйл	Анхаарах зүйл
<b>Эдийн засаг</b>	- Дадлага хичээлийн материаллаг хэрэгцээг бүрэн хангах боломжтой. - Олдоц ихтэй, хямд материал, дахин засварлах,угсрах, Үнэ өртөг хямд	Дахин боловсруулах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалах
<b>Нийгмийн</b>	-Дахин ашиглах боломжтой материалыг ашиглан хөөмөл, бэлэг дурсгалын зүйл гм эд зүйл хийж сурч байгаа нь гэр бүл, хамт олны хүрээнд бага ч гэсэн нэмэр хандив болно гэж үзэж байна.	- Дахин ашиглах боломжтой материалуудыг цуглуулах аян сургуулийн хэмжээнд зохион байгуулах - Хийсэн бүтээлээ сурталчлан таниулах, урамшуулан дэмжих
<b>Экологийн</b>	Байгалийн болон дахин ашиглах боломжтой материалыг нөөцлөн хадгалж, дахин боловсруулж эд зүйл, бүтээгдэхүүн хийж байгаа нь сайн талтай.	- Үйлдвэрлэх, хэрэглэхэд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх
<b>Соёлын</b>	--Өвөг дээдсийнхээ Урлахуйн ухааны онцлог, арга барилыг сурвалжлах, түүх судраас уншиж судлах, ахмадаасаа суралцах бүрэн боломжийг нээж өгч байна.	-Уламжлалт технологийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

**Тандах судалгаа 1 :** Дахин ашиглах боломжтой материалуудыг хаяхгүйгээр хаана ангилан ялгаж, нөөцлөж хадгалах боломжтой вэ? Судалгаанд 9 – 12 ангийн 139 сурагч хамрагдав.




**Судалгааны дүгнэлт 1 :** Сургуулийн гадна ангилан, ялгаж хогийн сав байршуулах 38 сурагч буюу 27.3%, сургуулийн коридорт 31 сурагч 22.3%, Дизайн технологийн кабинетад 23 сурагч 16.5% байршуулах нь боломжтой гэж хариулсан байна.

**Тандах судалгаа 2 :** Ашиглалтын хэрэглээнээс гарсан материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалах явцад та бүхэнд ямар сэтгэгдэл төрж байсан бэ? Судалгаанд 9а,б,в,г ангиудын 59 сурагч хамрагдав.



**Тандах судалгаа 3 :** Та бүхэн дахин боловсруулах боломжтой материалуудаас ямар материалыг нь сонгож, хүний хэрэгцээтэй эд зүйл хийсэн бэ? Судалгаанд 10 – 12 ангийн 67 сурагч хамрагдав.




**Судалгааны дүгнэлт 3 :** Судалгаанаас харахад арьс шир, модны өөдөс, хуудсан металлыг ашиглан бүтээл хийх сонирхол байвч, материалыг яаж боловсруулах арга технологи дутмаг байгаа нь хичээлийн явцад харагдаж байв.

**Тандах судалгаа 4 :** Өнөөдрийн дадлага ажлын хичээлийн материал хэрхэн хангагдсан байна вэ? Судалгаанд 9 б,г ангиудын 30 хамрагдсан болно.



**Судалгааны дүгнэлт 4 :** Судалгаанаас харахад 28 сурагч буюу 95 % нь хичээлийн материал сэтгэл ханамжтай , 2 сурагч буюу 5 % нь өөрөө бэлдэж ирэх материалаа авчиргаагүй гэж хариулснаас үзэхэд дизайн технологийн хичээлд дахин ашиглах боломжтой материалыг сургалтын хэрэглэгдэхүүн болгож ашиглах нь зөв гэсэн дүгнэлтэнд хүрэв.

**Тандах судалгаа 5 :** Энэ хичээлээр бие дааж, багаараа хамтарч ажиллах арга барил хэр зэрэг олж авсан гэж бодож байна вэ? Судалгаанд 60 сурагч хамрагдав.



**Судалганы дүгнэлт 5 :** Дээрхи судалгаанаас харахад хангалттай сайн, хангалттай гэж / 75% буюу 45 сурагч / нь бие дааж, хамтарч ажиллах арга барил хөгжиж байгаа гэж үзсэн нь сайн талтай.

### Судалгаат хичээлийн үр дүн :

Дадлага ажлын материаллаг хэрэгцээг шийдэж, хичээлийн үр дүнг сайжруулахын тулд Үнэлгээг тоон болон чанарын талаас нь хийх нь орчин үеийн сургалтын технологийн нэн чухал асуудал юм. Иймд чанарын талын үнэлгээг сурагчдын мэдлэг, чадвар, хөгжлийн ахиц болон төлөвшил хөгжлийн ахицыг сайжруулах судалгаат хичээлийг 9 ангийн А,Б,В ангиудад туршин зааж , ажиглалт судалгааг явуулснаас гадна Аймгийн Залуу багш нарын ур чадварын уралдааныг өөрийн нэрэмжит болгон 9 дахь жилдээ зохион байгуулж, өөрийн ажлын арга туршлагаа солилцож байна. Ингээд судалгааны үр дүнг та бүхэндээ толилуулъя.

### Үнэлгээг чанарын талаас нь хийж үзэхэд :

Чанарын үнэлгээ	Мэдлэг, чадварын хөгжлийн ахиц							Төлөвшлийн хөгжлийн ахиц		
	Шинжлэх ухааны мэдлэгийг эзэмшиж байгаа байдал	Хичээлээр олсон мэдлэгээ өдөр тутмынхаа амьдралд хэрэглээ болгож байгаа эсэх	Мэдлэг, чадварыг үйл ажиллагаан дээр тулгуурлан эзэмшиж буй байдал	Өдөр тутмын амьдралд тохиолдсон эерэг, сөрөг асуудлыг шийдвэрлэхэд эзэмшсэн мэдлэгээ хэрэглэж чадаж байгаа эсэх	Учир шалтгаант таамглал дэвшүүлж, туршилт ажиглалт хийж, бодит байдлаас дүгнэлт хийх чадвар	Мэдлэг, чадвар үнэхээр хэрэгцээтэй , гүн бат мэдлэг болон үлдэж чадсан эсэх	Өөрийн бодол саналаа чөлөөтэй илэрхийлж, уншиж, бичиж, зурсан зүйлээ товч тодорхой илэрхийлэх чадвар	Сурах арга барил эзэмшилт	Бие даан ажиллах	Бусадтай хамтарч ажиллах
Хичээл заалт - 1	85	74,0	88.0	71.5	66.0	72.0	76.0	86.3	74.4	87.0
Хичээл заалт - 2	86.5	77.0	96,0	77.3	72,0	75,0	85.5	88.0	85,0	96.5

### Судалгааны дүгнэлт : ( Сурагчдад гарч буй өөрчлөлт )

Судалгаат хичээлд 9 –р ангийн а,б,в бүлгийн 44 сурагч хамрагдав.

- Судалгааг Тоон талаас нь хийхэд стандарт хангалтын хувь улсын дунджаас 6.5% - иар ахисан байна
- Үнэлгээг чанар талаас нь хийхэд : Сурагчдын мэдлэг чадварын хөгжлийн ахиц 3 – 5.3 %, төлөвшлийн ахиц 3.5 – 7.3% ахисан байна.
- Дадлага хичээлийн материаллаг баазыг шийдснээр сурагчдын хичээлд оролцох идэвхи сонирхол дээшилж, сурагчдын бие даан ажиллах, хамтын үйл ажиллагаа ( аливааг хийж бүтээх, эргэцүүлэн бодох, нэгтгэн дүгнэх чадвар төлөвшиж ) байгаа нь хичээлийн явцад харагдаж байлаа.
- Дадлага хичээлээр сурагчид бүтээлдээ дараахь шаардлагыг тавьж ажилласнаар эдийн засгийн боловсрол олж авсан.
- Сурагчдын зурах, тооцоолох, бодох, урлан бүтээх үйл ажиллагаа сайжирч өөрийн бодол санаагаа зураг болон бүтээлээр илэрхийлэх чадвар эрс нэмэгдсэн нь хичээл заалтын явцад ажиглагдсан.

### Багшид гарч буй өөрчлөлт :

- Хичээлийг олон талаас нь олон хувилбарт хөтөлбөр боловсруулж хичээлийн чанараа ахиулах, өөрөө заах арга, арга зүйгээ сайжруулах сайн талууд байна

### Ерөнхий дүгнэлт, санал :

- Дизайн технологийн хичээлийн дадлага ажлын материаллаг хэрэгцээг шийдэж хичээлийн үр дүнг дээшлүүлэх сайжруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.

- Хэрэгцээнээс гарсан дахин ашиглах боломжтой материалуудыг нөөцлөн хадгалж, ангилан ялгаж, сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж үйл бүтээж байгаа нь сайн талтай болох нь сургалтын явцад ажиглагдсан.

**Санал :**

- Сургуулийн Дизайн технологийн Заах аргын нэгдлийн хамт олноос жилд нэг удаа дахин ашиглах боломжтой материалуудыг ангилан ялгаж, нөөцлөн хадгалах аян зохион байгуулж, сургалтын материаллаг хэрэгцээг шийдэх бүрэн боломжтой юм.

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН , БАРИМТ БИЧИГ :**

БСШУЯ . Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ 2016

БСШУЯ . Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр УБ. 3015

**НОМ СУРАХ, БИЧИГ :**

- [1] Бурмаа Б, Нэргүй Н, Батчулуун Б ... “ Тогтвортой хөгжлийн боловсрол “ УБ 2008
- [2] Бурмаа.Б. Оюунцэцэг Н, Батцэцэг Б ... Багш нарт зориулсан сургалтын гарын авлага / Тогтвортой хөгжлийн боловсрол /- I хэсэг
- [3] Гоцбаяр.Г. МУБИС доктор (Ph.D),“ Зураг зүйн сургалтын технологид уламжлалт арга ухагдахууныг тусгах нь “ илтгэл. “ Технологи, дүрслэх урлаг, зураг зүй , дизайны боловсролын орчин үеийн чиг хандлага “ УБ 2011.х-78 -80
- [4] Бага, дунд боловсролын технологийн боловсрол стандарт
- [5] Баяр мөнх. Г. Сургалтын технологийн шинэчлэл УБ. 2002
- [6] Боловсрол судлал сэтгүүл № 2008. 02
- [7] Боловсрол судлал сэтгүүл . № 2009. 10
- [8] Гоцбаяр.Г. МУБИС доктор (Ph.D),“ Зураг зүйн сургалтын технологид уламжлалт арга ухагдахууныг тусгах нь “ илтгэл. “ Технологи, дүрслэх урлаг, зураг зүй , дизайны боловсролын орчин үеийн чиг хандлага “ УБ 2011.х-78 -80
- [9] Технологи, дүрслэх урлаг, зураг зүй, дизайны боловсролын орчин үеийн чиг хандлага “Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал . УБ 2011
- [10] Сэрээтэрдорж Д. доктор (Ph.D) “ Технологийн боловсрол олгох сургалтын уламжлал, шинэчлэл, хандлага “ илтгэл УБ 2004
- [11] Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр . Дизайн технологи УБ 2016

**ЦАХИМ, ЭХ СУРВАЛЖ :**

[www.google.mn](http://www.google.mn)

[www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn)

[www.itpd.mn](http://www.itpd.mn)

[www.tacher.sur.mn](http://www.tacher.sur.mn)



**БАГШ, СУРАГЧДЫН ХИЙСЭН БҮТЭЭЛЭЭС ТА БҮХЭНД ТОЛИЛУУЛЬЯ.**

